

Сувилахуйн оюутнуудын хичээлээс халшрах хам шинж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан дүн

Э.Оюун-Эрдэнэ¹, Г.Хулан²¹Монгол Хьондай эмнэлэг²АШУҮИС, Сувилахуйн сургууль, НЭМСТЦахим шуудан: bns21c053@st.mn.ums.edu.mn, Утас: 85244231

Түлхүүр үг:

Хичээлээс
халшрах
хам шинж
Сувилахуйн
оюутнууд
Нөлөөлөх
хүчин зүйлс

Товч утга:

Үндэслэл: Хичээлээс халшрах хам шинж нь сурлагын амжилтанд сөргөөр нөлөөлдөг. Хичээлийн ачааллаас үүдэн оюутнууд хичээлээс шантрах, суралцах идэвхгүй болох, ядаргаа болон архаг стресс өртдөг байна. Сувилагч болон эмч нар дээр халшрах шинжийг тодорхойлсон судалгааны ажил цөөнгүй байдаг боловч сувилахуйн оюутнуудын дунд эдгээрийг тодорхойлсон судалгааны ажил хомс байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Сувилахуйн оюутнуудын хичээлээс халшрах хам шинж болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах. **Арга, аргачлал:** Бид энэхүү судалгааг АШУҮИС-ийн сувилахуйн сургуулийн сувилахуйн бакалаврын 1-4-р дамжааны нийт 671 оюутнаас санамсаргүй түүврийн аргаар 250 оюутныг сонгон авч агшингийн судалгааны загвараар 2024 оны 12 сараас 2025 оны 2 сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Хичээлээс халшрах шинжийг Маслачийн (MBI) үнэлгээний стандарт асуумжийг ашиглан хийсэн. **Үр дүн:** Судалгаанд 17-52 насны 250 оролцогч хамрагдсан бөгөөд 242 (96.8%) нь 22 ба түүнээс доош настай, дундаж утга ($\mu \pm 20.01$) байлаа. Хичээлээс халшрах хам шинжийн оноо 74 буюу дунд түвшинд байв. Нийт хичээлээс халшрах шинжид нас, гэрлэлтийн байдал, ажил эрхлэлтийн байдал хамааралгүй ба статистикийн хувьд ач холбогдолгүй байв. Харин хувийн халшрах шинж ($r = .95$, $P < .000$), хичээлтэй холбоотой халшрах шинж, хамт олноос шалтгаалсан халшрах шинж ($r = .98$, $P < .000$), багшаас шалтгаалсан халшрах шинж ($r = .94$, $P < .000$) эерэг хүчтэй хамааралтай статистикийн хувьд ач холбогдолтой байв. **Дүгнэлт:** Хувийн, хичээлийн агуулгатай холбоотой, хамт олноос болон багшаас шалтгаалсан халшрах байдал тус бүр дунд түвшинд байлаа.

Үндэслэл: Сувилахуйн оюутнуудын хичээлээс халшрах хам шинж нь дэлхийн улс орнуудад тулгамдсан асуудал болсоор байна. Ялангуяа анагаахын болон сувилахуйн оюутнуудын дунд хичээл таслах, халшрах хам шинж их байгааг судалгааны үр дүн харуулж байна. Хичээлээс халшрах хам шинжээс болж хичээлийн хөтөлбөрт хамрагдах хүсэлгүй байх, байнга таслах, хичээлийн үйл ажиллагаанд идэвхгүй болох, хичээл сурах чадваргүй болох, сургуулиас завсардах, толгой өвдөх, хэвлийгээр өвдөх, нойрны эмгэг, хоол тэжээлийн дутагдал зэрэг бие махбодын болон сэтгэл зүйн хүндрэлүүд гардаг байна. Мөн эмнэлзүйн дадлагын үед таагүй туршлага, ажиглалт зэрэг бусад стрессийг бий болгодог байна.¹ Жишээ нь: эмчлүүлэгч нас барах, өвдөлт, зовлон зүдүүрийг ажиглах, алдаа гаргахаас айх, янз бүрийн аюултай халдварт өвчнийг эмчлэх, клиникийн бусад ажилтнуудтай харилцах

харилцаа, олон төрлийн ур чадвар, мэдлэгийг эзэмших хэрэгцээ болон байнгын стресс нь хичээлээс халшрах гол шалтгаануудын нэг болдог. Хичээлээс халшрах хам шинж нь сурлагын амжилтанд сөргөөр нөлөөлдөг төдийгүй хичээлийн ачааллаас үүдэн оюутнууд хичээлээс шантрах, суралцах идэвхгүй болох, оюун санааны ядаргаа, архаг стресст өртдөг болохыг цөөнгүй судлаачид онцолсон байна.²

Швед улсын судлаач Агхажари (Aghajari, 2018) нарын судалгаагаар нэгдүгээр дамжааны оюутнуудын 29.7%, хоёрдугаар дамжааны оюутнуудын 36.9% нь хичээлээс халшрах хам шинжтэй гэсэн бол Ираны судлаач Годс (Ghods AA, 2022) нар анагаахын оюутнуудын дунд ядрах, сургалтын үйл ажиллагаанаас халшрах байдал нь бусад улс орнуудтай харьцуулахад өндөр байгааг тодорхойлжээ. Иранд хийсэн аналитик судалгаагаар анагаахын оюутнуудын хичээлээс

халшрах хам шинжийн онооны дундаж нь 49.2% байсан ба энэ нь жирийн сургуулийн оюутнуудын дунджаас өндөр байна. Өмнөх судалгаануудын үр дүнгээс харахад хичээлээс халшрах хам шинжид хувийн шинж чанар, хоорондын харилцаа болон орчны хүчин зүйлс нөлөөлдөг байна¹. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (СЭМҮТ)-ийн эмч, сувилагч, туслах сувилагч нарын дунд ажлаас халшрах хам шинжийн тархалт, нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон судалгаа хийхэд судалгаанд нийт 103 ажилтан хамрагдсан бөгөөд халшралын гурван үзүүлэлт болох ЕЕ (сэтгэл хөдлөлийн сульдалт), DP (хувийн бус хандлага), РА (ажлын бүтээмж бууралт)-ийн түвшинг хэмжихэд сэтгэл хөдлөлийн сульдалт хамгийн өндөр буюу 27%, хувийн бус хандлага 22.8%, ажлын бүтээмж бууралт 50.5% гэсэн байна. Ажлын халшралт болон оролцогчдын нийгэм, ажил, хувь хүний нөхцөл байдлын хоорондын уялдаа холбоог шинжлэхэд дараах үр дүн гарсан. Сэтгэл хөдлөл сульдлийн хувьд өдөрт хүлээн авч буй өвчтөний тоо болон ажлаасаа сэтгэл ханамжтай эсэх нь статистикийн хувьд өндөр ач холбогдолтой ($p < 0.001$). Хувийн бус хандлагатай холбоотой үзүүлэлтэд албан тушаалын онцлог нь мөн өндөр ач холбогдолтой ($p < 0.001$) хамааралтай байжээ. Түүнчлэн сэтгэл хөдлөлийн сульдалтийн түвшин нас, ажиллаж буй тасаг нэгжээс, хувийн бус хандлага нь цалин болон өдөрт хүлээж авдаг өвчтөний тооноос; харин ажлын бүтээмж бууралт болон хувийн бус хандлага аль алинд нь амьдрах орчны нөхцөл нөлөөлж байгааг тогтоосон байна.³ Гэсэн хэдий ч эдгээр судалгаанууд ихэвчлэн эмч, сувилагч нарын дунд ажлаас халшрах хам шинжийн талаар хийгдсэн бол, сувилахуйн оюутнуудын дунд хичээлээс халшрах

хам шинжийг нарийвчлан судалсан ажил хомс байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон юм.

Зорилго: Сувилахуйн оюутнуудын хичээлээс халшрах хам шинжийн түвшинг үнэлж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах.

Арга, аргачлал: Энэхүү судалгааг бид агшингийн судалгааны загвараар хийв. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн бакалаврын 1-4 дүгээр дамжааны нийт 250 оюутанг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулсан. Судалгаанд Маслах болон Сюзан нарын боловсруулсан асуумжаар мэдээлэл цуглуулав. АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын хорооны 2024 оны 11 сарын 20-ны өдрийн 24-25/02 тоот хурлын шийдвэрээр судалгааны ажлыг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл авсан. Судалгааны мэдээллийн боловсруулалтыг SPSS-26.0 программыг ашиглан хийсэн. Дескриптив статистикийн дүн шинжилгээгээр дундаж утга, стандарт хазайлт, их бага утгыг тооцоолсон. $P \leq 0.05$ байхад статистикийн хувьд ач холбогдолтой гэж үзлээ.

Үр дүн: Судалгаанд нийт 250 оюутнууд хамрагдсанаас насны хязгаар 17-52 насны хооронд байсан ба 242 (96.8%) нь 22 ба түүнээс доош настай, дундаж утга ($\mu \pm 20.01$) байлаа. Хүйсийн хувьд 236 (94.4%) нь эмэгтэй, 14 (5.6%) нь эрэгтэй оюутан байв. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь буюу 242 (96.8%) гэрлээгүй оюутнууд байлаа. Ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл 60 (24%) нь ажил эрхэлдэг, 190 (76%) нь ажил эрхэлдэггүй гэж хариулжээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын хүн ам зүйн үзүүлэлтүүд (n=250)

	Үзүүлэлт	Оюутнуудын тоо	Эзлэх хувь
Нас	≤ 22	242	96.8%
	> 23	8	3.2%
Хүйс	Эрэгтэй	14	5.6%
	Эмэгтэй	242	96.8%
Дамжаа	1-р дамжаа	65	26%
	2-р дамжаа	65	26%
	3-р дамжаа	60	24%
	4-р дамжаа	60	24%
Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн	8	3.2%
	Гэрлээгүй	242	96.8%
Ажил эрхлэлтийн байдал	Ажил хийдэггүй	60	24%
	Ажил хийдэг	190	76%

Судалгаанд оролцсон 250 оюутны “Хичээлээс халшрах шинж”-ийн нийт үзүүлэлт “Дунд” түвшинд байв. Хувийн, хичээлийн агуулгатай холбоотой, хамт олноос болон багшаас шалтгаалсан халшрах байдал

тус бүр дундаж оноотой байна. Нийт хичээлээс халшрах шинжийн онооны дундаж 62.56 бөгөөд энэ нь мөн дунд түвшинд байна. (Хүснэгт 2)

Хүснэгт2. Судалгаанд хамрагдсан оюутнуудын хичээлээс халшрах шинжийн түвшин дескрептив дүн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Боломжит утга	Одоогийн утга	Дундаж утга ($\pm$)	Түвшин
Хувийн халшрах шинж	5-12 бага		16.09 $\pm$ 3.66	Дунд
	13-17 дунд	17		
	18-25 их			
Хичээлээс халшрах шинж	7-16 бага		15.72 $\pm$ 3.75	Дунд
	17-24 дунд	19		
	25-35 их			
Хамт олноосоо халшрах шинж	6-12 бага		15.28 $\pm$ 3.79	Дунд
	13-22 дунд	19		
	23-30 их			
Багшаас шалтгаалсан халшрах шинж	6-12 бага		15.46 $\pm$ 3.82	Дунд
	13-22 дунд	19		
	23-30 их			
Нийт халшрах шинж	24-47 бага		62.56 $\pm$ 14.54	Дунд
	48-79 дунд	74		
	80-120их			

Нийт хичээлээс халшрах хам шинжид нас, гэрлэлтийн байдал, ажил эрхлэлтийн байдал хамааралгүй ба статистикийн хувьд ач холбогдолгүй байв. Харин хувийн халшрах шинж ($r=.95$, $P<.000$), хичээлтэй холбоотой халшрах шинж ($r=.98$, $P<.000$),

хамт олноос шалтгаалсан халшрах шинж ($r=.98$, $P<.000$), багшаас шалтгаалсан халшрах шинж ($r=.94$, $P<.000$) эерэг хүчтэй нөлөөлж статистикийн хувьд ач холбогдолтой байлаа. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдагсдын хичээлээс халшрах шинж (XXXIII) хүн ам зүйн асуумжийн хоорондын хамааралын дүн шинжилгээ

Үзүүлэлт	Нас	Анги дамжаа	Гэрлэлтийн байдал	Ажил эрхлэлтийн байдал	Хувийн халшрах шинж	Хичээлтэй холбоотой халшрах шинж	Хамт олноос шалтгаалсан халшрах шинж	Багшаас шалтгаалсан халшрах шинж	Нийт хичээлээс халшрах хам шинж
Нас	-								
Анги дамжаа	.442**	-							
Гэрлэлтийн байдал	-.343**	.034	-						
Ажил эрхлэлтийн байдал	-.172**	-.087	.164**	-					
Хувийн халшрах шинж	.036	.065	-.051	-.111	-				
Хичээлтэй холбоотой халшрах шинж	.051	.070	-.050	-.110	.969**	-			
Хамт олноос шалтгаалсан халшрах шинж	.046	.088	-.052	-.096	.904**	.956**	-		
Багшаас шалтгаалсан халшрах шинж	.033	.118	-.008	-.099	.821**	.881**	.954**	-	
Нийт XXXIII	.043	.088	-.042	-.107	.954**	.983**	.986**	.946**	

Сувилахуйн сургуульд суралцаж буй 1-4 р дамжааны оюутнуудын хичээлээс халшрах шинжийг Маслах болон Сюзан нарын боловсруулсан 24 асуумжийг Ликертийн 5 оноогоор тодорхойлон судаллаа.

Хэлцэмж: Бид судалгааныхаа үр дүнг бусад судлаачдын үр дүнтэй харьцуулахад Али Асгар Годс (2024) А нарын хийсэн судалгаанд нийт 91 оюутан оролцсон ба үр дүн нь MBISS-ийн янз бүрийн ангиллын дундаж оноог харуулсан. Үүнд нийт халшрах шинж 27.30

оноотой сэтгэлзүйн туйлдалт 7.21 байна. Эмэгтэй, эрэгтэй оюутнуудын хичээлийн ядаргааны нийт оноо болон түүний дэд үзүүлэлтүүдэд мэдэгдэхүйц ялгаа байхгүй байгаа нь манай судалгаатай харьцуулахад халшрах шинж өндөр байгаа нь бидний судалгаанаас ялгаатай байна⁴.

MBI-SS-ийн гурван хэмжээст шалгуурын дагуу сувилахуйн суралцагчдын нэгээс гурав нь (38.2%) сэтгэлзүйн туйлдалттай байгаа нь харагдсан. Гэхдээ эмийн суралцагчдын дунд сэтгэлзүйн туйлдалтын түвшин нь улс орноос хамааран ялгаатай байдаг. Одоогийн судалгааны үр дүн нь Саудын Араб дахь Шахид болон түүний хамтран ажиллагчдын явуулсан судалгаатай ойролцоо байгаа бөгөөд тэдний судалгаагаар эмийн суралцагчдын 38.2% нь өндөр сэтгэлзүйн туйлдалттай байсан. Харин бусад судалгаанууд, тухайлбал, Саудын Араб дахь Алтанир (2023) А нарын судалгаанууд, 13.4% болон 14.9%-ийн бага түвшинд сэтгэлзүйн туйлдалт илэрсэн байв. Өндөр сэтгэл зүйн туйлдалтын түвшин нь Кербала хотын анагаахын сургууль болон Иракийн бусад анагаахын сургуулиудын дарамттай сургалтын орчныг тусган харуулж магадгүй юм. Гэвч сэтгэлзүйн туйлдалтын түвшний ялгаанууд нь эмийн суралцагчдын сэтгэл зүйн туйлдалтыг үнэлэхэд ашигласан хэрэгсэлүүдийн ялгаатай байдалтай холбоотой байж болох юм. Мөн зарим судалгаа хоёр хэмжээст шалгуурыг ашигласан бөгөөд энэ нь одоогийн судалгааны гурван хэмжээст шалгуураас илүү ерөнхий байдаг. Түүнчлэн оюутнуудын сэтгэлзүйн дарамт болон сэтгэлзүйн туйлдалт нь онлайн сургалтаар нэмэгдсэн гэж үздэг. Иймээс COVID-19 цар тахлын үед хөл хорио болон онлайн сургалтад шилжих шаардлага эмийн суралцагчдын сэтгэлзүйн туйлдалтын түвшинд нөлөөлсөн байж болзошгүй юм.

Дүгнэлт: Нийт хичээлээс халшрах шинжид нас, гэрлэлтийн байдал, ажил эрхлэлтийн байдал хамааралгүй ба статистикийн хувьд мөн адил ач холбогдолгүй байна. Харин хувийн халшрах шинж ($r=.95$, $P<.000$), хичээлтэй холбоотой халшрах шинж ($r=.98$ $P<.000$), хамт олноос шалтгаалсан халшрах шинж ($r=.98$, $P<.000$), багшаас шалтгаалсан халшрах шинж ($r=.94$, $P<.000$) эерэг хүчтэй хамааралтай статистикийн хувьд ач холбогдолтой байв.

Ном зүй:

1. Aghajari, Zohreh, et al. "The relationship between quality of learning experiences and academic burnout among nursing students of Shahid Beheshti University of Medical Sciences in 2015." *Electronic Journal of General Medicine* 15.6 (2018).
2. Bordoagni G, Fino E, Agostini A. Burnout, Attachment and Mentalization in Nursing Students and Nurse Professionals. *Health-care (Basel)*. 2021 Nov 18;9(11):1576. doi: 10.3390/healthcare9111576. PMID: 34828621; PMCID: PMC8624246.
3. Д.Одончимэг, З.Хишигсүрэн, Д.Хонгорзул, Э.Мөнх, Б.Баярмаа,

Энхтайван, О.Баатаржав, З.Цэндүрэн, Э.Сэлэнгэ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ажилчдын дунд ажлаас халшрах хам шинжийг MASLACH ийн асуумжийн аргаар тодорхойлсон нь. 2015 ; *Innovation Iyulрал*

4. Ghods AA, Ebadi A, Sharif Nia H, Allen KA, Ali-Abadi T. Academic burnout in nursing students: An explanatory sequential design. *Nurs Open*. 2023 Feb;10(2):535-543. doi: 10.1002/nop2.1319. Epub 2022 Aug 18. PMID: 36631731; PMCID: PMC9834498.
5. WHO, *International Classification of Diseases, 11th Revision*, 2019
6. Schaufeli & Enzmann, 1998
7. Maslach, C.; Jackson, S.E. (1981). "The measurement of experienced burnout". *Journal of Occupational Behavior*. 2 (2): 99–113. doi:10.1002/job.4030020205
8. Maslach, C.; Jackson, S.E.; Leiter, M.P. (1996–2016). *Maslach Burnout Inventory Manual (Fourth ed.)*. Menlo Park, CA: Mind Garden, Inc.
9. Maslach, C., Jackson, S.E., Leiter, M.P., Schaufeli, W.B. and Schwab R.L. (1986) *Maslach burnout inventory sampler set manual, general survey, human services survey, educators survey, & scoring guides*. Mind Garden Publishers, Menlo Park.
10. Maslach C, Jackson SE, Leiter MP: *Maslach Burnout Inventory Manual*. 3rd edition. Palo Alto, CA: Consulting Psychologists Press; 1996:29-46.
11. Hwang E, Kim J. Factors affecting academic burnout of nursing students according to clinical practice experience. *BMC Med Educ*. 2022 May 6;22(1):346. doi: 10.1186/s12909-022-03422-7. PMID: 35524256; PMCID: PMC9077997.
12. Njim T, Mbanga C, Mouemba D, Makebe H, Toukam L, Kika B, Mulango I. Determinants of burnout syndrome among nursing students in Cameroon: cross sectional study. *BMC Res Notes*. 2018 Jul 9;11(1):450. doi: 10.1186/s13104-018-3567-3. PMID: 29986754; PMCID: PMC6038299.
13. Kong LN, Yao Y, Chen SZ, Zhu JL. Prevalence and associated factors of burnout among nursing students: A systematic review and meta-analysis. *Nurse Educ Today*. 2023 Feb; 121:105706. doi: 10.1016/j.nedt.2022.105706. Epub 2022 Dec 23. PMID: 36577286.
14. Prakash P, Sheilini M, Nayak SG. Academic burnout among undergraduate nursing students: A quantitative survey approach. *J Educ Health Promot*. 2023 Apr 28; 12:141. doi: 10.4103/jehp.jehp_1120_22. PMID: 37397125; PMCID: PMC10312481.
15. Dyrbye, L. N., Thomas, M. R., & Shanafelt, T. D. (2006). Systematic review of depression, anxiety, and other indicators of psychological distress among U.S. and Canadian medical students. *Academic Medicine*, 81(4), 354–373.
16. Rella, S., Winwood, P. C., & Lushington, K. (2009). When does nursing burnout begin? An investigation of the fatigue experience among nursing students. *Journal of Nursing Management*, 17(7), 886–897.
17. Kim, K. H. (2009). Burnout among nursing students in Korea. *Nurse Education Today*, 29(5), 572–576.
18. Labrague, L. J. (2013). Stress, stressors, and stress responses of student nurses in a government nursing school. *Health Science Journal*, 7(4), 424–435.
19. Kong LN, Yao Y, Chen SZ, Zhu JL. Prevalence and associated factors of burnout among nursing students: A systematic review and meta-analysis. *Nurse Educ Today*. 2023 Feb; 121:105706. doi: 10.1016/j.nedt.2022.105706. Epub 2022 Dec 23. PMID: 36577286.
20. Hwang E, Kim J. Factors affecting academic burnout of nursing students according to clinical practice experience. *BMC Med Educ*. 2022 May 6;22(1):346. doi: 10.1186/s12909-022-03422-7. PMID: 35524256; PMCID: PMC9077997.

Academic Burnout and Its Influencing Factors among Nursing Students

Oyun-Erdene E¹, Khulan G²

¹Mongolia Hyundai Hospital

²Department of Public Health Nursing, School of Nursing, MNUMS

E-mail: bns21c053@st.mnum.s.edu.mn, Tel: +976-85244231

Abstract:

Background: Academic burnout negatively affects academic performance. Excessive academic workload may lead students to disengagement from learning, reduced motivation, mental fatigue, and chronic stress.

Aim: To examine academic burnout and its influencing factors among nursing students.

Material and Methods: This cross-sectional study was conducted among undergraduate nursing students' years 1–4 at the School of Nursing, MNUMS. From a total population of 671 students, 250 were selected using simple random sampling. Data were collected between December 2024 and February 2025 using the Maslach Burnout Inventory Scale (MBI).

Results: Participants ranged in age from 17 to 52 years; 242 (96.8%) were aged 22 years or younger, with a mean age of 20.01 years. The overall academic burnout score was 74, indicating a moderate level of burnout. Age, marital status, and employment status were not significantly associated with overall burnout. However, personal burnout ($r=.95$, $p<.000$), study-related burnout and peer-related burnout ($r=.98$, $p<.000$), and teacher-related burnout ($r=.94$, $p<.000$) showed that strong positive correlations and were statistically significant.

Conclusion: Personal factors, study-related factors, peer-related factors, and teacher-related factors contributing to burnout were each at a moderate level.

Keywords: Academic burnout, Nursing students, Influencing factors